Эх баригч мэргэжилтний үгэн бус харилцааны ур чадварыг үнэлсэн дүн

А.Амарбаясгалан[1], П.Цэцэгмаа[2], Х.Цэцэгсүрэн[2], Д.Гандолгор[1], М.Мэндбаяр[1], Г.Ганхуяг[2], Б.Оюунгоо[2]
[1] Өргөө Амаржих Газар
[2] АШУҮИС-Сувилахуйн сургууль
Цахим шуудан: gnu21e302@gt.mnums.edu.mn Утас 89981851

Түлхүүр үг:
харилцааны ур чадвар, цогц чадамж, сургалт, үйлчлүүлэгч

Товч утга:

Үндэслэл: ЭМС-ын А/451 дугаар тушаалаар эх баригч мэргэжилтний төгсөлтийн дараах цогц чадамжийг баталсан. Эх баригчийн цогц чадамж гэдэг нь эх, нярай, эмэгтэйчүүд, тэдгээрийн гэр бүлд нөхөн үржихүйн болон эх барихуйн тусламж үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах мэргэжлийн үнэ цэнэ, мэдлэг, ур чадвар, харилцаа хандлагын цогц ойлголт юм.[1] Цогц чадамжийг бүрдүүлэх 6 чадварын нэг нь “харилцагч” байх чадвар юм. Манай улсад эх баригчийн харилцааны ур чадварыг ажлын байран дээр үнэлсэн судалгаа хараахан хийгдээгүй байгаа нь энэхүү судалгааг хийх үндэслэл боллоо. Зорилго: Өргөө Амаржих Газарт ажиллаж буй эх баригч мэргэжилтний үгэн бус харилцааны ур чадварыг үнэлж, түүнд нөлөөлөх нийгэм, хүн ам зүйн хүчин зүйлийн хамаарлыг тодорхойлох. Арга, аргачлал: ДЭМБ-ын “Төрөлтийн эерэг туршлагыг сайжруулахад чиглэсэн төрөх үеийн тусламж үйлчилгээ” удирдамж, Дэлхийн эх баригчдын нийгэмлэгээс гаргасан баримт бичгүүдэд тохирсон байдлыг харгалзан судлаач Alimoradi нарын боловсруулсан нээлттэй үнэлгээний хуудсаар Нийслэлийн Өргөө Амаржих Газарт ажиллаж буй 49 эх баригчийг судалгаанд хамруулж, дескриптив судалгааны нэг агшингийн загвараар үгэн бус харилцааны ур чадварыг ажиглалтын аргаар үнэлж, нийгэм хүн ам зүйн хүчин зүйлтэй холбон судлав. Үр дүнг SPSS 26.0 программаар тооцоолов. Үр дүн: Судалгааны явцад ажлын байран дээр 49 эх баригчийн 196 удаагийн ажиглалтыг хийсэн. Судалгаанд хамрагдсан эх баригч нарын дундаж нас 35.38±9.22, 50% нь дундажаар 6-16 жилийн ажлын туршлагатай, 77.6% нь гэрлэсэн, 81.6% нь улсын сургуульд суралцаж, бакалаврын боловсрол эзэмшсэн, 100% хөдөлмөрийн гэрээ байгуулсан үндсэн ажилтан байв. Эх баригчдын 42.9% нь цалин орлогын байдалдаа сэтгэл дундуур байсан. Ажлын ачааллын байдлаар 65.3% нь өдөрт 30 ба түүнээс дээш хүнд үйлчилдэг ба үйлчлүүлэгчийн тоо нэмэгдэхэд үйлчлүүлэгч нэг бүртэй ганцаарчлан харилцах байдал буурсан (p=0.043). Нас нэмэгдэхэд үйлчлүүлэгчийг сонсож байх явцдаа үгэн бус дохио үзүүлж харилцах чадвар нэмэгдэж байсан (p=0.015). Харилцааны ур чадварын сургалтанд хамрагдаагүй эх баригч нар үйлчлүүлэгчтэй харилцах явцдаа биеийн байрлалаа буруу байрлалд байршуулж байгаа нь (p=0,022) ажиглагдсан. Шөнийн ээлжинд ажиллаж буй эх баригч нар үйлчлүүлэгчтэй нүүр царайны хувирал үзүүлж харилцах чадвар буурсан (p=0.045) байв. Өдрийн ээлжинд ажиллаж буй эх баригч нарт үйлчлүүлэгчийн яриаг нь таслахгүй сонсох чадвар (p=0.017) сайн байсан. Дүгнэлт: Эх баригчийн үгэн бус харилцааны ур чадвар нь цалиндаа сэтгэл хангалуун эсэх, харилцааны ур чадварын сургалтанд хамрагдсан эсэх болон ажлын цагийн ачаалалтай шууд хамааралтай байна.

Үндэслэл: 2018 онд Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гаргасан “Төрөлтийн эерэг туршлагыг сайжруулахад чиглэсэн төрөх үеийн тусламж үйлчилгээ” удирдамжид зааснаар жирэмсэн болон төрөх эхэд тусламж үйлчилгээ үзүүлэх эмнэлгийн мэргэжилтэн болон төрөгч эх хооронд энгийн, соёлын хувьд хүлээн зөвшөөрөгдөхүйц үр дүнтэй харилцааг бий болгохыг зөвлөсөн байна. Мөн тус зөвлөмжид төрөгч эмэгтэйн хүсэл сонирхол, хэрэгцээ шаардлага болон асуултад нь хүндэтгэлтэй хандах, еерэг хандлагаар хариу үйлдэл үзүүлэх, идэвхтэй сонсогч байхыг зөвлөсөн байна.[2]

Дэлхийд жилд ойролцоогоор 140 сая гаруй эхчүүд төрдөг ба дийлэнх хувийг хүндрэлгүй хэвийн төрөлт эзэлж буй хэдий ч жирэмсэн болон төрөгч эхэд үзүүлэх эх барихуйн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах нь эмнэлгийн нэн тэргүүний зорилт юм.[2,3] Үйлчлүүлэгч төвтэй, үр дүнтэй харилцааг бий болгосноор учирч болох аюул, эмнэлгийн алдаа үүсэхээс сэргийлэх, таслах зогсооход илүү хялбар болдог байна. Сүүлийн 10 гаруй жилийн турш удирдлагын, хүний хүчин зүйлийн болон харилцааны доголдол нь жирэмсэн болон төрөх эхэд тусламж үйлчилгээ үзүүлэх явцад урьдчилан төсөөлөөгүй алдаанд хүргэдэг байна.[4]

Харилцааны ур чадвар нь эх барихуйн тусламж үйлчилгээний хамгийн чухал суурь элемент болдог бөгөөд эхэд үзүүлэх тусламж үйлчилгээний чанарыг сайжруулахын тулд эх баригч мэргэжилтний харилцааны ур чадварыг сайжруулах нь эхийн эрүүл мэндийг дээшлүүлэх түлхүүр болдог байна.[4,5] Судалгаагаар үгэн бус харилцаагаар агуулгын 55%, дуу хоолойны өнгөөр 38%, ердөө 7% нь амаар илэрхийлэгддэг гэсэн байна.[6] Эх баригч болон жирэмсэн, төрөх эхийн хооронд үр дүнтэй, сайн харилцаа бий болсноор эхийн стрессийн түвшин буурах, амар тайван мэдрэмжийг авах, сэтгэл ханамж нэмэгдэх, цусны даралт буурах, айдас, өвдөлт нь багасах, хамгаалагдсан мэт мэдрэмж төрөх, эмч, эх баригчийн гаргасан шийдвэрийг хүлээн авч дагах, өөрөөрөө төрж чадна гэсэн итгэл төрөх, төрөлтийн явцад илүү сайн өөрийгөө хянах чадвартай байх зэрэг олон давуу талыг бий болгодог байна.[7]

Зорилго: Эх баригч мэргэжилтний үгэн бус харилцааны ур чадварыг үнэлж, түүнд нөлөөлөх нийгэм, хүн ам зүйн хүчин зүйлийн хамаарлыг тодорхойлох.

Зорилт:

1. Эх баригч мэргэжилтний үгэн бус харилцааны ур чадварыг үнэлэх.
2. Эх баригч мэргэжилтний үгэн бус харилцааны ур чадвар болон түүнд нөлөөлөх нийгэм, хүн ам зүйн хүчин зүйлийн хамаарлыг тодорхойлох.

Арга, аргачлал: ДЭМБ-ын “Төрөлтийн еерэг туршлагыг сайжруулахад чиглэсэн төрөх үеийн тусламж үйлчилгээ” удирдамж, Дэлхийн эх баригчдын нийгэмлэгээс гаргасан баримт бичгүүдэд тохирсон байдлыг харгалзан судлаач Alimoradi нарын боловсруулсан нээлттэй үнэлгээний хуудсаар Нийслэлийн Өргөө Амаржих Газарт ажиллаж буй 49 эх баригчийг судалгаанд хамруулж, дескриптив судалгааны нэг-агшингийн загвараар үгэн бус харилцааны ур чадварыг үнэлсэн. Нэг эх баригчийг 4 удаа буюу нийт 196 удаагийн ажиглалт хийсэн ба ажиглалт бүрт үгэн бус харилцааны 10 шалгуур асуултын дагуу үнэлж, нийгэм хүн ам зүйн хүчин зүйлтэй холбон судлав. Ажиглалтыг Монгол Улсын MNS4621:2008 түгээмэл үйлдлийн стандартад заагдсан үйлдлүүд болон эх баригч мэргэжилтний ажлын байрны тодорхойлолтод заасан үйлдлийг гүйцэтгэх явцад хийсэн. Асуумжийн найдвартай байдлыг Кронбах альфа коэффициентоор тодорхойлов. Кронбах альфа коэффициентын утга нэг рүү дөхөх тусам найдвартай болохыг илтгэх бөгөөд утга нь 0.79 байсан тул асуумжийг судалгаанд ашиглав.

Судалгаа хийх ёс зүйн зөвшөөрлийг АШУҮИС-ийн судалгааны ёс зүйн хяналтын хорооны 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хурлын шийдвэрээр авсан. (Хурлын тэмдэглэл 2023.06.16 №2023/3-07).

Үр дүнгийн статистик боловсруулалтыг SPSS 26.0 программ ашиглан хийлээ. Судалгааны мэдээллийг кодлон SPSS 26.0 программд оруулж, өгөгдлийн алдааг хянаж, тохирох статистик тестийг ашигласан (хамаарлын шинжилгээ, хи квадрат тест, p, Fisher exact test) ба p утга 0,05-аас бага байх тохиолдолд статистик үнэн магадлалтай гэж үзсэн.

Үр дүн: Судалгаанд Нийслэлийн Өргөө Амаржих Газарт ажиллаж буй 49 эх баригчийг хамруулсан. Судалгаанд оролцогчдын нас 24-59 хооронд хэлбэлзэж, дундаж нас нь 35.38 (SD=9.22) ба ажилласан жилийн дундаж нь 12.44 (SD=9.47), 1-40 жил ажилласан, судалгаанд оролцогчдын дийлэнх нь буюу 77.6% (n=38) нь гэрлэсэн, 81.6% (n=40) нь улсын сургуульд суралцаж, бакалаврын боловсрол эзэмшсэн байсан. Судалгаанд оролцогчдыг өдөрт хэдэн хүнд үйлчилдгээр нь ангилж үзвэл 2% (n=1) нь 10 хүртэл хүнд, 22.4% (n=11) нь 11-20 хүнд, 10.2% (n=5) нь 21-30 хүнд, 65.3% (n=32) нь өдөрт 30 ба түүнээс дээш хүнд үйлчилдэг байв. Цалингийн сэтгэл ханамжийг авч үзвэл 22.4% (n=11) нь сэтгэл хангалуун, 34.7% (n=17) нь зарим талаараа сэтгэл хангалуун, 42.9% (n=21) нь сэтгэл дундуур гэж тус тус хариулсан (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Судалгаанд оролцогчдын хүн ам зүйн ерөнхий мэдээлэл (n=49)

Үзүүлэлт	Бодит тоо (n)	Эзлэх хувь (%)
Нас (жил) (=35.38, SD=9.22, Range=24-59)		
Ажлын туршлага (жил) (=12.44, SD=9.47, Range=1-40)		
Гэрлэлтийн байдал		
Гэрлэсэн	38	77.6
Гэрлээгүй	11	22.4
Боловсрол		
Диплом	9	18.4
Бакалавр	40	81.6
Төгссөн сургууль		
Хувийн	9	18.4
Улсын	40	81.6
Цалингийн сэтгэл ханамж		
Сэтгэл хангалуун	11	22.4
Зарим талаараас сэтгэл хангалуун	17	34.7
Сэтгэл дундуур	21	42.9
Харилцаа хандлагын сургалтанд хамрагдсан эсэх		
Хамрагдсан	33	67.3
Хамрагдаагүй	16	32.7
Өдөрт хэдэн хүнд үйлчилдэг эсэх		
10 хүртэлх хүнд	1	2
11-20 хүнд	11	22.4
21-30 хүнд	5	10.2
30-аас дээш хүнд	32	65.3
Нийт	49	100

Үгэн бус харилцааны ур чадвар: Нийт 196 удаагийн ажиглалтад эх баригч нарын үйлчлүүлэгчтэй харилцахдаа эелдэг найрсаг буюу дуу хоолойны өнгөө тохируулан харилцах чадвар 83.7%, эмнэлгийн ажилтны стандарт хувцаслалт бүхий гадаад төрхийг бүрдүүлсэн 77.6%, үйлчлүүлэгчийн ярианд таслахгүйгээр сонсох чадвар 73.5% сайн байв. Нийт ажиглалтын үр дүнг тооцоолоход үйлчлүүлэгчийн биед үзлэг, шинжилгээ хийхдээ хувийн нууцлалт байдлыг хадгалаагүй 22.4%, үйлчлүүлэгчийн нүдрүү харж, нүдээрээ холбоо тогтоож харилцаагүй 16.3%, үйлчлүүлэгчийг сонсох явцдаа үгэн бус дохио үзүүлж харилцаагүй 12.2%, үйлчлүүлэгчтэй харилцахдаа нүүрний хувирал үзүүлээгүй, зөв байрлалд сууж харилцаагүй тус тус 8.2% зэрэг нь огт хийгдээгүй байна (Хүснэгт2).

Хүснэгт 2. Үгэн бус харилцааны ур чадвар тус бүрийн үнэлгээ

№	Үгэн бус харилцааны ур чадварууд	Гүйцэтгэлийн хувь				
		100%	**75%**	**50%**	**25%**	**0%**
		4	**3**	**2**	**1**	**0**
1	Эмнэлгийн ажилтны стандарт хувцаслалттай бүхий гадаад төрхийг бүрдүүлсэн	77.6	14.3	8.2	0.0	0.0
2	Үйлчлүүлэгчтэй харилцахдаа зөв байрлалд сууж байсан (хүн хоорондын зай баримталсан, үйлчлүүлэгчрүү харсан)	49.0	16.3	12.2	14.3	8.2
3	Үйлчлүүлэгчтэй харилцахдаа эелдэг найрсаг буюу дуу хоолойны өнгөө тохируулан харилцсан	83.7	14.3	2.0	0.0	0.0
4	Үйлчлүүлэгчийн нүдрүү харж, холбоо тогтоож харилцсан	49.0	18.4	12.2	4.1	16.3
5	Үйлчлүүлэгчтэй харилцахдаа нүүрний хувирал үзүүлсэн	40.8	22.4	14.	14.3	8.2
6	Хийж буй үйлдэлдээ тохируулан биеийн байрлалаа өөрчилсөн	53.1	26.5	12.2	6.2	2.0
7	Үйлчлүүлэгчийн ярианд таслахгүйгээр сонссон	73.5	12.2	10.2	2.0	2.0
8	Үйлчлүүлэгчийг сонсох явцдаа үгэн бус дохио үзүүлсэн	36.7	18.4	18.4	14.3	12.2
9	Үйлчлүүлэгчийн биед үзлэг шинжилгээ хийхдээ хувийн нууцлалт байдлыг хадгалсан	12.2	6.1	30.6	28.6	22.4
10	Үйлчлүүлэгчидтэй нэг, нэгээр нь уулзах буюу үйлдлээ бүрэн гүйцэт хийсний дараа дараагийн хүнд үйлчилсэн	61.2	20.4	18.4	0.0	0.0

Үгэн бус харилцааны ур чадвар ба хүн ам зүйн хүчин зүйл хоорондын хамаарал: Ажилласан жил, гэрлэлт, боловсролын түвшин, төгссөн сургууль зэрэг нь үгэн харилцааны ур чадвартай хамааралгүй байсан. Насны хувьд нас нэмэгдэхэд үйлчлүүлэгчийг сонсож байхдаа үгэн бус дохио үзүүлэх чадвар нэмэгдэж ($p=0.015$) байсан. Цалиндаа сэтгэл дундуур байдаг гэж хариулсан оролцогчдын хувьд үйлчлүүлэгчтэй харилцах явцдаа нүүрний хувирал үзүүлэх чадвар ($p=0.037$) буурсан, харилцааны ур чадварын сургалтанд

хамрагдаагүй эх баригч нар үгэн бус харилцааны 2 дахь шалгуур буюу үйлчлүүлэгчтэй харилцах явцдаа биеийн байрлалаа буруу байрлалд байршуулж (p=0.022) байсан. Өдөрт 30-аас дээш хүнд үйлчилдэг гэж хариулсан эх баригч нар үйлчлүүлэгчидтэй нэг нэгээр нь уулзах буюу нэг хүнд нэг үйлдлээ бүрэн гүйцэт дуусгасны дараа дараагийн үйлчлүүлэгчид шилжиж үйлчлэх чадвар буурсан (p=0.043) байна. Шөнийн ээлжинд ажиллаж буй эх баригч нар үйлчлүүлэгчтэй нүүр царайны хувирал үзүүлж харилцах чадвар буурсан (p=0.045), өдрийн ээлжинд ажиллаж буй эх баригч нарын үйлчлүүлэгчийн ярианг таслахгүйгээр сонсох чадвар сайн (p=0.017) байв.

Хэлцэмж: Бидний судалгаанд тодорхойлсноор эх баригчийн үгэн бус харилцааны ур чадвар нь харилцаа хандлагын сургалтанд хамрагдсан эсэх, өдөрт үйлчилдэг хүний тоо буюу ажлын ачаалал, цалингийн сэтгэл ханамж, нас, өдөр шөнийн аль ээлжинд ажиллаж буй эсэхтэй статистикийн хувьд ялгаа бүхий хамааралтай байсан. Харин ажлын туршлага, гэрлэлтийн байдал, боловсролын түвшин, төгссөн сургууль болон үгэн бус харилцааны ур чадвар хоорондоо статистикийн хувьд ач холбогдол бүхий хамааралгүй байв. Бусад судлаачдын судалгаанд ажиглагдсанаар эх баригчийн үйлчлүүлэгчтэй харилцах үгэн бус харилцааны ур чадварт ажлын туршлага, гэрлэлтийн байдал нь нөлөө бүхий хамааралгүй нь батлагдсаар байна.[5,8] Тухайлбал Ираны судлаач Khadivzadeh (2015) нарын 49 эх баригчийн үгэн болон үгэн бус харилцааны ур чадварыг ажиглалтын аргаар үнэлсэн судалгаанд эх баригчийн харилцааны ур чадвар болон гэрлэлтийн байдал, ажилласан жилийн хооронд хамааралгүй болох нь батлагдсан.[5] Тус судалгаанд хамрагдсан эх баригч нарын нас 23-57 хооронд хэлбэлзэж, дундаж нас 39.11±9.66 жил, ажлын туршлага 15.9±8.77 жил байгаа нь бидний судалгааны үр дүнтэй дүйж байна.

Taghizadeh (2007) нарын 50 эх баригчийн үйлчлүүлэгчтэй харилцах харилцааны ур чадварыг ажиглалтын аргаар үнэлсэн судалгаанд эх баригчийн ажлын туршлага нь үгэн бус харилцааны ур чадварт нөлөө бүхий хамааралгүй байсан нь бидний судалгаанд мөн ажиглагдсан.[8] Alimoradi (2013) нарын судалгаанд ажиглагдсанаар эх баригчийн үгэн бус харилцааны ур чадвар болон ажлын туршлага, боловсролын түвшин хооронд хамааралгүй байсан нь бидний судалгааны үр дүнтэй дүйж байлаа. Тус судалгаад эх баригч нарын 46% нь цалиндаа сэтгэл дундуур байгаа нь бидний судалгааны 42.9% гэж тодорхойлсонтой ойролцоо байв.[9] Эх баригчийн үгэн бус харилцааны ур чадварт ажлын туршлага, гэрлэлтийн байдал, боловсролын түвшин зэрэг хүчин зүйлүүд хамааралгүй байгаа нь нийтийг хамарсан сургалтыг ажлын байран дээр тогтмол зохион байгуулах нь илүү үр дүнтэй байх боломжтойг илэрхийлж байж болох юм. Өөрөөр хэлбэл судлаачдын үгэн бус харилцааны ур чадварыг үнэлсэн судалгаанд үгэн бус харилцааны ур чадвар дундаж болон хангалтгүй түвшинд үнэлэгдэж байгаа нь сургалтыг тогтмол давтамжтай явуулах эрэлт хэрэгцээ байгааг илэрхийлж байх боломжтой юм. Тухайлбал Taghizadeh (2007) нарын судалгаанд эх баригч мэргэжилтний үгэн бус харилцааны ур чадвар 56%, эх баригчийн үгэн бус харилцааны ур чадварт үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж 48.4% байсан байна.[8]

Эх баригч мэргэжилтний харилцааны ур чадвар нь эрүүл мэндийн тогтолцооны хөгжлийн төлөвлөгөөнд хамгийн чухал ач хобогдолтой учир эх барихуйн боловсролын салбарт энэхүү онцгой хэрэгцээг анхаарч орчин үеийн сургалтын арга хэрэгслийг ашиглан хэрэгжүүлж ажиллах, цаашид харилцаа хандлагын тал дээр үргэлжлүүлэн хяналт тавьж ажиллахыг зөвлөсөн байна.[7]

Дүгнэлт:

1. Эх баригч мэргэжилтний эмнэлгийн ажилтны стандарт хувцаслалт бүхий гадаад төрхийг бүрдүүлэх, үйлчлүүлэгчтэй эелдэг найрсгаар дуу хоолойны өнгөө тохируулан харилцах, үйлчлүүлэгчийн ярианг таслахгүй сонсох ур чадварууд хангалттай сайн түвшинд байна.
2. Эх баригчийн үгэн бус харилцааны ур чадвар нь цалиндаа сэтгэл хангалуун эсэх, харилцааны ур чадварын сургалтанд хамрагдсан эсэх болон ажлын цагийн ачаалалтай шууд хамааралтай байна.

Ном зүй:

1. *<МУ-ын ЭМС-ын А451 дугаар тушаал.pdf>.*
2. *<WHO positive experience.pdf>.*
3. *Butler MM, Fullerton J, Aman C. Competencies for respectful maternity care: Identifying those most important to midwives worldwide. Birth. 2020;47(4):346-356.*
4. *Lyndon A, Johnson MC, Bingham D, et al. Transforming communication and safety culture in intrapartum care: A multi-organization blueprint. Journal of Obstetric, Gynecologic & Neonatal Nursing. 2015;44(3):341-349.*
5. *Khadivzadeh T, Katebi MS, Sepehri Shamloo Z, Esmaily H. Assessment of Midwives' Communication Skills at the Maternity Wards of Teaching Hospitals in Mashhad in 2014. Journal of Midwifery and Reproductive Health. 2015;3(3):394-400.*
6. *<Эмнэлгийн мэргэжилтний харилцааны сэтгэл зүй.pdf>.*
7. *Katebi MS, Khadivzadeh T, Sepehri Shamloo Z, Esmaily H. Evaluating Midwives Communication Skills from the Perspective of Parturient Women Attending to Hospitals for Delivery. Journal of Midwifery and Reproductive Health. 2017;5(2):882-889.*
8. *Taghizadeh Z, Rezaiepour A, Mehran A, Alimoradi Z. Usage of communication skills by midwives and its relation to clients' satisfaction. Hayat. 2007;12(4):47-55.*
9. *Alimoradi Z, Taghizadeh Z, Rezaypour A, Mehran A. Evaluation of midwives' communication skills. African Journal of Midwifery and Women's Health. 2013;7(1):19-24.*

Evaluation of midwives’ communication skills

Amarbayasgalan A[1], Tsetsegmaa P[2], Tsetsegsuren Kh[2], Gandolgor D[1], Mendbayar M[1], Gankhuyag G[2], Oyungoo B[2]
1 Urguu Specialized Maternity Hospital
2 School of nursing, MNUMS
E-mail: gnu21e302@gt.mnums.edu.mn, Tel: - 976-89981851

Keywords:
communication skill, competencies, training, patient

Background: The postgraduate comprehensive competencies for midwifery practice were approved by Order No. A/451 of the Ministry of Health. One of the six competencies is the ability to be a “communicator”. In my country, there has been no study evaluating the communication skills of midwives in the workplace, which is the reason for conducting this study. **Aim:** Evaluate the midwives’ communication skills who work at Urguu Maternity Hospital and explore their association with sociodemographic factors. **Materials and methods:** The communication skills were evaluated using a cross-sectional method. A survey was conducted by observing while midwives completed their regular procedures for diagnosis and treatment and the duties listed in their job descriptions and Mongolian Standard MNS4621:2008. Data obtained from the study were analyzed using SPSS 26.0 package software, and p values ≤0.05 were considered statistically significant. **Results:** Among the 49 participants, with a mean age of 35.38±9.22, half of them have had 6–16 years of experience, 77.6% were married, and 81.6% completed governmental university and had a bachelor’s degree. 100% of the respondents are full-time employees with employment contracts, and 42.9% are dissatisfied with their salary. 65.3% of midwives served 30 or more patients per day. It is observed that when the number of patients increases, one-on-one interaction is reduced, and it is statistically significant (p = 0.043). It is increasing nonverbal cues while listening to patients (0.015) as the age of the midwife increases. Midwives who did not participate in communication skills training do not sit in the correct position toward patients (0.022). Midwives facial expression is reduced (0.045) for those who work in the night shift. Additionally, a positive correlation was found between midwives who work on the day shift and their non-verbal communication skills of listening carefully and not interrupting patients while speaking (0.017). **Conclusion:** Despite being a good listener to assess midwives’ nonverbal communication skills, the patient’s privacy during the examination is inadequate.